



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/282

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Батдайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас 90 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Цэвээндоржийн Жавзандулам /ПО89061821/-д хаягийг Батмонгол 2 дүгээр гудамжны 201 тоот болгон 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэнд үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Зах.А/282.Сн
02 01231